



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

Мансууруулах болон сэтгэцэд
нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх,
ханган нийлүүлэх журам батлах тухай

Монгол улсын Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 10.1, 24.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.12.4 дэх заалтууд, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх журам”-ыг нэгдүгээр, “Монгол Улсын хүн амын эмчилгээнд хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт”-ыг хоёрдугаар, “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн импортын лицензийн загвар”-ыг гуравдугаар, “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн импортын лиценз хүсэх өргөдлийн загвар”-ыг 4 дүгээр хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэс /М.Уранчимэг/, Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс /Г.Ганчимэг/ нарт тус тус даалгасугай.

3. Эрүүл мэндийн байгууллагад мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг хадгалах, хэрэглэхэд тавих дотоодын хяналтыг сайжруулж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн болон эм хангамжийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2011 оны 400 дугаар тушаал, 2012 оны 359 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 02 сарын 24 өдрийн
68 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

МАНСУУРУУЛАХ БОЛОН СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ ЭМИЙГ ИМПОРТЛОХ, ҮЙЛДВЭРЛЭХ, ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1 Энэхүү журмын зорилго нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, тэдгээрийн түүхий эд (цаашид “мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм” гэх)-ийн импорт, үйлдвэрлэл, хангамжтай холбоотой асуудлыг Монгол Улсын “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай”, “Мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” болон “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн хүрээнд зохицуулж, хяналт тавихад оршино.

1.2 Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэхэд энэ чиглэлээр аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/ -тэй байна.

1.3 Мансууруулах эмээр үйлчлэх эмийн санг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын тушаалаар тогтооно.

1.4 Шинжилгээ, судалгааны зориулалтаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг ашиглахад Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолыг мөрдөнө.

1.5 Тусгай зөвшөөрөл бүхий эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр нь энэхүү тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан эмээр эрүүл мэндийн байгууллага, эмийн санг тасралтгүй, жигд, хүртээмжтэй, сонголт хийх боломж бүхий үнээр хангах зарчмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

Хоёр. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох

2.1 Эмчилгээний зориулалтаар Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн импортын лицензийг тухайн эмийн жилийн хэрэгцээг үндэслэн Эрүүл мэнд, спортын яамнаас тухай бүр 6 сарын хугацаагаар олгоно.

2.2 Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг урьдчилан тогтоосон хэрэгцээнээс нэмж импортлох шаардлагатай гэж үзвэл энэ тухай Эрүүл мэнд, спортын яаманд мэдэгдэж, тус яамнаас Олон улсын мансууруулах бодисын хяналтын зөвлөлөөр шийдвэрлүүлсэн тохиолдолд импортын лиценз олгоно.

2.3 Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн импортын лиценз хүсэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

- 2.3.1 мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийн хуулбар;
- 2.3.2 экспортлогч талтай байгуулсан албан ёсны гэрээ;
- 2.3.3 эм, эмийн түүхий эдийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- 2.3.4 импортын лиценз хүссэн өргөдөл /маягтын дагуу/

3.3.6 “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулинд заасан бусад баримт бичиг;

3.4 Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм үйлдвэрлэх болон ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллага нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

3.4.1 эзэмшиж буй тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлтээ хугацаа дуусахаас 2 сарын өмнө бичгээр гаргах;

3.4.2 үйлдвэрлэх болон импортлох эмийн хэрэгцээг өмнөх оны эхний улиралд багтаан зөвшөөрөл олгогч байгууллагад мэдэгдэж, тухайн жилийн хэрэгцээнд тусгуулсан байх;

3.4.3 импортлосон болон үйлдвэрлэсэн эмийн түүхий эд, эмийн нэр, тун, хэлбэр, цувралын дугаар, тоо хэмжээ, тэдгээрийг хүлээн авсан, түгээсэн болон зарцуулсан хэмжээ, экспортлогчийн нэрийг илтгэсэн бүртгэлийг тогтмол хөтлөх;

3.4.4 холбогдох тайланг зөвшөөрөл олгогч байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлж байх;

Дөрөв. Мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийг хэрэглэх

4.1 Мансууруулах эмийг эмнэлгийн нөхцөл, хөнгөвчлөх эмчилгээний хоспис, шаардлагатай тохиолдолд эмчийн бичсэн жорын дагуу гэрийн эмчилгээнд болон яаралтай тусламж үйлчилгээнд хэрэглэнэ.

4.2 Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн тасгийн захиалгыг бусад эмнээс тусад нь эмчилгээ эрхэлсэн орлогч даргаар баталгаажуулна.

4.3 Эрүүл мэндийн байгууллагад мансууруулах эмийг эмчилгээнд хэрэглэхэд дараах хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

4.3.1 сувилагч нь эмчлэгч эсхүл жижүүрийн эмчийн хяналтан дор мансууруулах эмийг өвчтөнд хэрэглэнэ.


4.3.2 мансууруулах эмийг үйлдвэрийн савласан хэмжээнээс бага тун, хэмжээгээр өвчтөнд хэрэглэх тохиолдолд илүү гарсан эмийн үлдэгдлийг ажлын цагаар эмчлэгч эмчийн, ажлын бус цагаар жижүүрийн /тухайн эмчилгээ үйлчилгээ үзүүлсэн/ эмчийн хяналтын дор тухай бүр хөндлөнгийн гэрч байлцуулан устгаж, баримтжуулна.

4.3.3 мансууруулах эмийг өвчтөнд хэрэглэсэн бол тухайн эмийн нэр, цувралын дугаар, хэрэглэсэн аргыг өвчтөний түүхэнд тодорхой бичиж, баталгаажуулан, хэрэглэсэн эмийн хоосон тун шил, шахмал эмийн савыг эмийн санд эргүүлэн тушааж, тэмдэглэл хөтөлнө.

4.3.4 эмийн сан нь мансууруулах эмийн хоосон тун шил, шахмал эмийн савыг буцаан авсан тухай тусгай бүртгэл хөтлөн, жилд нэг удаа комисс томилон, хөндлөнгийн гэрч байлцуулан устгана.

4.4 Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг Засгийн газрын 2003 оны 196 тоот тогтоолын 4 дүгээр хавсралтад заасны дагуу хадгалах, устгах арга хэмжээг авна.

4.5 Эмийн сан нь хүлээн авсан, олгосон, устгасан мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн нэр, цувралын дугаар, огноо болон зарцуулалтын бүртгэл хөтөлж, бүртгэлийг 1 жил хадгалж, байгууллагын архивт шилжүүлнэ.



Тав. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн түгээлт, зарцуулалтын бүртгэл, тайлан

5.1 Тусгай зөвшөөрөл бүхий эмийн үйлдвэр нь үйлдвэрлэсэн эмийг зөвхөн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй эм ханган нийлүүлэх байгууллагад түгээнэ.

5.2 Тусгай зөвшөөрөл бүхий эм ханган нийлүүлэх байгууллага нь мансууруулах эмийг эрүүл мэндийн байгууллага болон мансууруулах эмээр үйлчлэх эрх бүхий эмийн санд нийлүүлэх бөгөөд тухайн байгууллагын захиалга, худалдан авах гэрээг үндэслэнэ.

5.3 Тусгай зөвшөөрөл бүхий эм хангамжийн байгууллагууд нь хоорондоо мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг дамжуулах буюу солилцож үл болно.

5.4 Нийтийн үйлчилгээтэй эмийн сан нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг шаардагдах мэдээллийг агуулсан хүчинтэй жор, үйлчлүүлэгчийн иргэний үнэмлэх /регистрийн дугаар бүхий баримт бичиг/-ийг үндэслэн заасан хэмжээгээр олгож, жорыг хураан авч, бүртгэл хөтлөн, хэрэглэх арга, илэрч болох гаж нөлөөнөөс сэргийлэх талаар дэлгэрэнгүй зааварчилгаа өгнө.

5.5 Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр үйлчилж буй эм хангамжийн болон эрүүл мэндийн байгууллага нь холбогдох бүртгэлийг үнэн зөв хөтөлж, тайланг хугацаанд нь гаргана. Үүнд:

5.5.1 нийтийн үйлчилгээтэй эмийн сан нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн орлого, зарлагын, зарцуулалтын болон устгалын бүртгэл, улирлын тайлан;

5.5.2 эмнэлгийн эмийн сан нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн орлого, зарлагын, устгалын болон эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдэд хэрэглэсэн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалтын бүртгэл;

5.5.3 эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн орлого, зарлагын болон устгалын бүртгэл, улирлын тайлан;

5.6 Эм хангамжийн болон эрүүл мэндийн байгууллага нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хөдөлгөөнийг дор дурдсан загварын дагуу хөтөлж, тайлагнана. Үүнд:

5.6.1 Нийтийн эмийн санд хөтлөгдөх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн орлого, зарлагын бүртгэл

Эмийн сангийн нэр _____

№	Огноо	Эмийн нэр, тун хэмжээ, хэлбэр	Цувралын дугаар	Нийлүүлэгчийн нэр	Баримтын дугаар	Эмийн тоо хэмжээ		
						Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл

5.6.2 Нийтийн эмийн санд хөтлөгдөх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалтын бүртгэл



Эмийн нэр, тун хэмжээ, хэлбэр _____

№	Огноо	Жорын индекс	Жор бичсэн огноо, эмчийн нэр	Өвчтөний нэр	Онош	Өвчтөний регистрийн дугаар	Олгосон		Эм олгогчийн нэр
							Эмийн цувралын дугаар	Эмийн тоо хэмжээ	

5.6.3 Эмнэлгийн эмийн санд хөтлөгдөх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн орлого, зарлагын бүртгэл

Эмийн нэр, тун хэмжээ _____ Хэмжих нэгж _____

Огноо	Эхний үлдэгдэл	Орлого			Зарцуулалт		Эцсийн үлдэгдэл
		Тоо	Цувралын дугаар	Нийлүүлэгчийн нэр	Тоо	Тасаг, нэгж	

5.6.4 Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдэд хэрэглэсэн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалтын бүртгэл

Эмнэлэг, тасгийн нэр _____

Эмийн нэр, тун хэмжээ _____ Хэмжих нэгж _____

№	Огноо	Өвчтөний			Хэрэглэсэн эмийн тоо хэмжээ					Эмчилгээ үйлчилгээ үзүүлсэн эмчийн нэр	Сувилагчийн нэр	
		Өвчтөний түүхийн дугаар	Нэр	Онош	Орлого	Буцаалт	Зарлага					Үлдэгдэл
							Тун	Хэрэглэсэн давтамж	Цувралын дугаар			

5.6.5 Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэрт хөтлөгдөх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн орлого, зарлагын бүртгэл

Эмийн нэр, тун хэмжээ, хэлбэр _____ Хэмжих нэгж _____



№	Огноо	Орлого			Зарлага			Үлдэгдэл тоо	
		Тоо	Цувралын дугаар	Импортын лицензийн дугаар	Нийлүүлэгчийн нэр	Олгосон	Байгууллагын нэр		Тоо

5.6.6 Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр, нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалтын тайлангийн маягт

Байгууллагын нэр _____ оны..... дугаар улирлын тайлан


№	Эм/ эмийн түүхий эдийн нэр, тун хэмжээ	Хэмжих нэгж	Эхний үлдэгдэл	Орлого	Цувралын дугаар	Нийлүүлэгчийн нэр	Зарлага	Эцсийн үлдэгдэл

5.6.7 Эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн санд хөтлөгдөх мансууруулах болон сэтгэц нөлөөт эм/түүхий эдийн устгалын бүртгэл

№	Эм, эмийн түүхий эдийн нэр	Хэмжих нэгж	Цувралын дугаар	Устгасан тоо хэмжээ	Мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийн дугаар	Шийдвэр гаргасан эрхийн актын дугаар, огноо	Тайлбар

5.7 Нийтийн үйлчилгээтэй эмийн сангууд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалтын тайланг хагас жилээр гарган 7 дугаар сарын 10-н болон дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор харьяа аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт ирүүлэх бөгөөд эмийн асуудал хариуцсан мэргэжилтэн тайланг нэгтгэн Цагдаагийн ерөнхий газрын мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хариуцсан нэгжид ажлын 10 хоногт багтаан хүргүүлнэ.

5.8 Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр нь дараах тайланг гаргаж ирүүлнэ. Үүнд:

- 
- 5.8.1 мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн дараа оны хэрэгцээг өмнөх жилийн татан авалт, тухайн жилийн захиалга зэргийг тооцон гаргаж, Эрүүл мэнд, спортын яаманд тухайн жилийн 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх;
- 5.8.2 импортлосон, үйлдвэрлэсэн эм, эмийн түүхий эдийн тайланг улирал болон жилээр гарган улирал бүрийн эхний сарын 05-ны дотор Эрүүл мэнд, спортын яаманд ирүүлэх;
- 5.8.3 импортлосон, үйлдвэрлэсэн эмийн зарцуулалтын тайланг хуульд заасны дагуу жил бүр гаргаж дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор Цагдаагийн ерөнхий газрын мансууруулах, сэтгэц нөлөөт эм, бодис хариуцсан нэгжид хүргүүлэх;

5.9 Эрүүл мэнд, спортын яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэс нь НҮБ-ын “Мансууруулах эмийн тухай” 1961 оны Нэгдсэн Конвенци, “Сэтгэц нөлөөт бодисын тухай” 1971 оны Конвенци, “Мансууруулах эм болон сэтгэц нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг” 1988 оны Конвенцид нэгдэн орсон Талын үүргийн хүрээнд холбогдох тайланг хугацаанд нь Олон улсын мансууруулах бодисын хяналтын зөвлөлд хүргүүлнэ.

Зургаа. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жор бичих, жорын маягтаар хангах

6.1 Эмийн найрлагад мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис эмчилгээний тунгаар орсон байвал эмч эмийн жор бичнэ.

6.2 Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорыг бичихдээ “Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376:2014 Монгол улсын стандартыг мөрдөнө.

6.3 Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар “Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376:2014 Монгол улсын стандартад заасан загварын дагуу хэвлүүлэн, дугаарлаж /индекс/, харьяа нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн байгууллагуудад түгээнэ.

6.4 Мансууруулах эмийн жорын маягтын дугаар нь тухайн аймаг, нийслэлийн Засаг захиргааны нэгжийн код болон 5 оронтой тоо, сэтгэц нөлөөт эмийн жорын маягт нь дээрх код болон 6 оронтой тооноос бүрдэнэ.

6.5 Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалтад орсон мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийг эдгээр эмийн жорын маягт болон даатгалын жорын маягт дээр бичиж хавсаргасан байна.

6.6 Төв эмнэлэг болон тусгай мэргэжлийн төвүүд нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтыг Нийслэлийн эрүүл мэндийн газарт захиалж авна.

6.7 Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтыг тухайн байгууллагын захиалга болон өмнө авсан жорын маягтын зарцуулалтын тайланг үндэслэн олгоно.

6.8 Эмнэлэг нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтын зарцуулалтын бүртгэл, тайланг дор дурдсан загварын дагуу гаргана. Үүнд:

- 6.8.1 Мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн жорын маягтын зарцуулалтын бүртгэл

№	Жорын индекс	Үйлчлүүлэгчийн нэр, регистрийн дугаар	Онош	Жоронд бичсэн эмийн нэр, тун, хэлбэр	Жор бичсэн эмчийн нэр, тасаг

6.8.2 Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтын зарцуулалтын тайлан

Эмнэлгийн нэр _____ оны..... -р сарын ... өдөр

Жорын маягт хүлээн авсан огноо	Жорын маягтын нэр, төрөл	Хүлээн авсан жорын маягтын		Зарцуулсан жорын маягтын		Үлдэгдэл	
		Индекс	Тоо	Индекс	Тоо	Индекс	Тоо

6.9 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь хэвлүүлж, түгээсэн мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн жорын тайланг дор дурдсан загварын дагуу гарган, дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор Эрүүл мэнд, спортын яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэс болон Цагдаагийн ерөнхий газрын мансууруулах, сэтгэц нөлөөт эм, бодис хариуцсан нэгжид хүргүүлнэ.

Эрүүл мэндийн газрын нэр _____

№	Хэвлүүлсэн мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн жорын маягтын тоо	Олгосон байгууллагын тоо	Олгосон жорын маягт		Үлдэгдэл
			тоо	дугаар	
1.	Мансууруулах эмийн жорын маягт				
2.	Сэтгэц нөлөөт эмийн жорын маягт				

Долоо. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хэрэглээнд хяналт тавих

7.1 Эрүүл мэндийн байгууллагын мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хадгалалт, хэрэглээ, зарцуулалт, устгал, жор бичилт, жорын маягтын зарцуулалтад эрүүл мэндийн байгууллагын чанарын алба хяналт тавьж ажиллана.

7.2 Эм хангамжийн байгууллагын мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хадгалалт, түгээлт, зарцуулалт, устгалд чанарын менежер хяналт тавьж ажиллана.

7.3 Энэхүү журмын хэрэгжилтийг хангуулах ажлыг Эрүүл мэнд, спортын яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэс зохион байгуулна.

7.4 Энэхүү журмын хэрэгжилтэнд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар хяналт тавьж ажиллана.

7.5 Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг хууль бусаар хэрэглэсэн, зарцуулсан тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээг авна.

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 02 сарын 24 өдрийн
68 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ЭМЧИЛГЭЭНД ХЭРЭГЛЭХ МАНСУУРУУЛАХ
БОЛОН СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ ЭМИЙН ЖАГСААЛТ

А. Мансууруулах эмийн жагсаалт

Олон улсын нэршил	Химийн нэршил
1. Бупренорфин	6R,7R,14S)-17-циклопропилметил-7,8-дигидро-7-[(1S)-1-гидрокси-1,2,2-триметилпропил]-6-0-метил-6,14-этано-17-норморфин
2. Дигидрокодеин	
3. Гидроморфон	дигидроморфинон
4. Кодеин	3-о-метилморфин
5. Леворфанол	(-)-3- гидроксид-N-метилморфинан
6. Морфин	
7. Метадон	6-диметиламино-4,4-дифенил-3-гептанон
8. Оксикодон	14-гидроксидигидрокодеинон
9. Оксиморфон	14- гидроксидигидроморфинон
10. Фентанил	1-фенетил-4-N-пропиониланилинопиперидин
11. Петидин	1-метил-4-фенилпиперидин-4-карбоксил ацид этил эстэр
12. Тримеперидин	1,2,5-триметил-4-фенил-4-пропионоксипиперидин

Б. Сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт

Олон улсын нэршил	Химийн нэршил
1. Аллобарбитал	5,5-диалилбарбитурын хүчил
2. Амобарбитал	5-этил-5-изопентилбарбитурын хүчил
3. Барбитал	5,5-диэтилбарбитурын хүчил
4. Бромзапам	7-бromo-1,3-дигидро-5-(2-пиридил)-2H-1,4-бензодиазепин-2-он
5. Глутетимид	2-этил-2-фенилглутаримид
6. Диазепам	7хлоро-1,3-дигидро-1-метил-5-фенил-2H-1,4-бензодиазепин-2-он
7. Залеплон	N -(3-(цианопиразоло [1,5-a]пиримидин-7-ил)фенил)-N-этилацедамид
8. Зопиклон	(RS) -6-(5-хлорпиридин-2-ил)-7-оксо-6,7-дигидро-5H-пирроло[3,4-b]пиразин-5-ил 4-метилпиразин-1-карбоксилат
9. Кетамин	2-(Метиламино)-2-(2-хлофенил)-циклогексанона гидрохлорид
10. Клоназепам	5-(о-хлорофенил)-1,3-дигидро-7-нитро-2H-1,4 бензодиазепин-2-он

- | | |
|---------------------|--|
| 11. Левомепромазин | 2-метокси-10-(3-диметиламино-2-метилпропил)-
фенотиазин гидрохлорид |
| 12. Мепробамат | 2-метил-2-пропил-1,3-пропанедиол бикарбамат |
| 13. Медазепам | 7-хлоро-2,3-дигидро-1-метил-5-фенил-1Н-1,4-
бензодиазепин |
| 14. Метамфетамин | (+)-(S)-N, α -диметилфенетиламин |
| 15. Метаквалон | 2-метил-3-о-толил-4(3Н)-хиназолинон |
| 16. Метилфенидат | метил- α -фенил-2-пиперидинацетат |
| 17. Метфеназат | 3,4,5-триметоксибензоат-2-хлор-10- $\{$ 3-[1- β -оксиэтил)-
пиперазинил-4]-пропил $\}$ -фенотиазина дифумарат |
| 18. Нитрозепам | 1,3-дигидро-7-нитро-5-фенил-2Н-1,4-бензодиазепин-2-он |
| 19. Пентобарбитал | 5-этил-5-(метилбутил) барбитурын хүчил |
| 20. Пентазоцин | (2R*6R*11R*)-1,2,3,4,5,6-гексагидро-6,11-диметил3-(3-
метил-2-бутенил) -2,6-метано-3-бензацосин-8-ол |
| 21. Пиназепам | 7-хлоро-1,3 дигидро-5- фенил- (2 пропил)-2Н-1, 4-
бензодиазепин-2-он |
| 22. Секобарбитал | 5-аллил-5-(метилбутирил) барбитурын хүчил |
| 23. Трифлуоперазин | 10-[3-(4-метил-пиперазинил)пропил]-2 (-трифторметил)—
10Н-фенотиазин дигидрохлорид |
| 24. Фенобарбитал | 5-этил-5-фенилбарбитурын хүчил |
| 25. Фторфеназин | 2-трифторметил-10- $\{$ 3-[1-(β -оксиэтил)-пиперазинил-4]-
пропил $\}$ -фенотиазин дигидрохлорид |
| 26. Циклобарбитал | 5-(1-циклогексен-1-ил)-5-этилбарбитурын хүчил |
| 27. Хлорпромазин | 2-хлор-10-(3-диметиламинопропил)-фенотиазин
гидрохлорид |
| 28. Хлордiazепоксид | 7-хлоро-2-(метиламино)-5-фенил-3Н-1,4-бензодиазепин-4-
оксид |
| 29 Эфедрин | L-1-фенил-2-метиламинопропанол |



Энэхүү жагсаалтанд заагдсан нэршил бүхий бодисууд, түүний давсуудыг агуулсан эм, эмийн түүхий эдийн бүх тун хэмжээ, хэлбэр болон худалдааны нэршлийг хамруулж ойлгоно.

Эрүүл мэнд, спортын сайдын
 2015 оны 02 сарын 24 өдрийн
 68 дугаар тушаалын 3 дугаар
 хавсралт



МАНСУУРУУЛАХ /СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ ЭМИЙН ИМПОРТЫН ЛИЦЕНЗ
 Import license of Narcotic /Psychotropic Drug

Экспортлогчийн нэр хаяг / Name and address of the exporter:		Зөвшөөрөл олгогч /Competent authority:			
		Зөвшөөрлийн дугаар / Authorization number:			
		Гэрээний дугаар / Contract №		Огноо / Date of issue	
Импортлогчийн нэр хаяг/ Name and address of importer:		Илгээх улс / Country of delivery		Гэрээт улс / Contracting country	
		Гарал үүсэл, улс / Country of origin		Хүлээн авах улс / Country of destination	
Тээврийн төрөл/ Mode of transport			Нэмэлт тайлбар / Supplementary details <input checked="" type="checkbox"/> Эмчилгээний зориулалтаар/ medical use <input type="checkbox"/> Эрдэм шинжилгээний зориулалтаар/ scientific use		
Хилийн боомт / Port of entry					
Эмийн олон улсын нэр /international non- proprietary name	Эмийн худалдааны нэр /brand name	Бүртгэл ийн дугаар/ Registra tion No	Тун хэмжээ/ Dosage	Хэмжих нэгж/ Unit	Тоо хэмжээ/ Quantity
Цэвэр бодисын агууламжийн хэмжээ /The quantity, expressed in terms of anhydrous base content/					
Зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын хугацаанд хүчинтэй./ License is valid within 6 months of the issue.					
Олгосон/ Issued by					
Монгол улсын Эрүүл мэнд, спортын яам Ministry of Health and sports of Mongolia		 Огноо / Date		
Тэмдэг/ Stamp					
..... / Гарын үсэг / Signature					

Эрүүл мэнд, спортын сайдын
 2015 оны 02 сарын 24 өдрийн
 ..68 дугаар тушаалын 4 дүгээр
 хавсралт

МАНСУУРУУЛАХ /СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ ЭМИЙН ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ХҮСЭХ
 ӨРГӨДӨЛ /Application form for import license of Narcotic / Psychotropic Drugs/

Экспортлогчийн нэр, хаяг / Name and address of exporter		Гэрээний дугаар / Contract number		Он сар өдөр / Date		
Импортлогчийн нэр, хаяг/ Name and address of importer		Илгээх улс / Country of delivery		Гэрээт улс / Contracting country		
		Гарал үүсэл / Country of origin		Хүлээн авах улс / Country of destination		
Тээврийн төрөл / Mode of transport						
Хилийн боомт / Port of entry		Нэмэгдэл тайлбар / Supplementary details <input type="checkbox"/> Эмчилгээний зориулалтаар/ medical use <input type="checkbox"/> Эрдэм шинжилгээний зориулалтаар/ scientific use				
Эмийн олон улсын нэр /international non- proprietary name	Эмийн худалдааны нэр /brand name	Бүртгэлийн дугаар/ Registration No	Тун хэмжээ/ dosage	Хэмжих нэгж / Unit	Тоо хэмжээ/ quantity	Нэгж үнэ/ unit price
Өмнөх зөвшөөрлийн гүйцэтгэл / Use of previous authorization						
Хавсаргасан баримт/ Attached documents 1. 2. 3. 4.						
Хянасан /Revised by						
Өргөдөл гаргасан / Applied by Байгууллагын /иргэний нэр Name of organization/person			Танилцсан/ Seen by			
Албан тушаалын нэр / Title			Тусгай тэмдэглэл/Notes			
Гарын үсэг/Signature			
Харилцах утас / Telephone			Он сар өдөр/Date			